



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

f [facebook.com/Vrtcc.m0n](https://www.facebook.com/Vrtcc.m0n)
globe <http://rtcc.mrt.d.gov.mn>
envelope info@rtcc.mrt.d.gov.mn
phone [+976 77244409](tel:+97677244409)

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2019 оны 02-р сарын дугаар



Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчлэсэн найруулгын төсөлд санал өглөө.



Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн олон нийтийн хэлэлцүүлэг 2019.02.26-нд төмөр замын соёлын ордонд боллоо. Тус хэлэлцүүлэгт төвөөс хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэмэлтээр тусгах

23, зарим зүйл, хэсэг, заалт, дэд заалтыг өөрчлөн найруулах нийт 205 саналыг нэгтгэж 2019.02.20-ны 39тоот албан бичгээр болон цахим шуудангаар ЗТХЯ-нд хүргүүлсэн бөгөөд хэлэлцүүлгийн явцад саналаа дэвшүүллээ.



Төмөр замын тээврийн салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог сайжруулахаар ажиллаж байна

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Салбарын мэргэжилтэй ажилтан болон мэргэжилтний мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар хуулийн 1 зүйл 5 заалт болгон оруулахаар саналаа тусгуулсан.



Салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог сайжруулахаар МБСҮЗөвлөлийн дэргэд Яамны ТнБ-ийн даргаар ахлуулсан Зам, тээврийн салбар зөвлөл байгуулагдаж МБСҮЗ-өөс зохион байгуулагдсан "салбар зөвлөл болон дэд салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах уулзалт, хэлэлцүүлэг"-т оролцож санал солилцлоо.





Стандартын төсөлд мэргэжлийн байгууллагуудаас санал авч ажиллалаа.

ISO 6346 “Ачааны чингэлэг-Кодчилол, нэгдсэн дугаарлалт, тэмдэглэгээ” стандартын төслийг орчуулан боловсруулж санал авахаар 2019.02.11-ний өдөр албан бичгээр ЗТХЯ-ны харьяа болон салбарын төрийн бус байгууллагуудад хүргүүлсэн. Дээрх байгууллагуудаас ирсэн саналуудыг нэгтгэн боловсруулж стандартын төсөлд тусгасан болно.



Суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийж байна.

Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргийн хүрээнд суурь бүтцүүдийн 2019 оны 02-р сарын тасалдлын мэдээг хүлээн авч, гүйцэтгэлд шинжилгээ хийж ЗТХЯ-ны ХШУДАГ-т хүргүүлэв.



Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгох ажлыг зохион байгуулах, бүртгэх, эрх бүхий хуулийн этгээдийг мэдээллээр хангах ажлын хүрээнд:

“Төмөр замын зураг төслийн институт” ХХК-ний 20 хагас вагонд дугаар олгон төвийн захирлын 2019.02.19-ний өдрийн 35 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн “УБТЗ ХНН”-ийн 2ТЭ25КМ серийн таван зүтгүүрт “Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт”. 3-р хэсэг. “Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага” МНС 6630-3:2016 стандартыг үндэслэн бүртгэлийн шинэ дугаарууд олгосон.






Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна

Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 01/92 дугаар тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу төмөр замын тээврийн тээвэрлэлтийн мэдээг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогыг хэрэгжүүлэх газар, Бодлого төлөвлөлтийн газарт хүргэж танилцуулсан.



2019 оны 2 дугаар сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа болон зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч болон ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны www.mrtd.gov.mn, төвийн www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ.



Төмөр замын холбогдолтой гадаад улсын сэтгүүлийн 02-р сарын дугаарыг төвийн цахим хуудсанд байршууллаа

Гадаад орнуудын төмөр замын салбартай холбоотой “Railway Illustrated”, “Trains” “Modern Railways” сэтгүүлийн 02-р сарын дугаарыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн төвийн www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэлээ.





Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх хэсэг, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журамд заасан мэдээллийг төвийн цахим хуудас болон Шилэн дансны цахим хуудсанд байршуулж мэдээлж байна. Шилэн дансны цахим хуудаст байршуулах мэдээллийг цаг тухай бүрт тайлагнасан.

№	МЭДЭЭЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨВИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАГНАСАН	2023				2024				2025				2026				
		1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	
1	Дээрх мэдээллийг төв хуудсанд оруулах																	
2	Төрийн байгууллагын мэдээллийг төв хуудсанд оруулах																	
3	Төрийн байгууллагын мэдээллийг төв хуудсанд оруулах																	
4	Төрийн байгууллагын мэдээллийг төв хуудсанд оруулах																	
5	Төрийн байгууллагын мэдээллийг төв хуудсанд оруулах																	
6	Төрийн байгууллагын мэдээллийг төв хуудсанд оруулах																	
7	Төрийн байгууллагын мэдээллийг төв хуудсанд оруулах																	
8	Төрийн байгууллагын мэдээллийг төв хуудсанд оруулах																	
9	Төрийн байгууллагын мэдээллийг төв хуудсанд оруулах																	



Төвийн мэдээллийн самбарыг тухай бүрт шинэчлэн олон нийтэд мэдээллийг хурдан шуурхай хүргэж ажилласан.

Мэдээллийн самбарт мэдээ мэдээллийг хуваарийн дагуу тогтмол шинэчлэн баяжуулж, зураг авалт хийн, баримтжуулж байна.

Зохногчийн эх

ЭЭРЭ БОЛ ГЭ

162 Өглөөний цайны цэр

162 Өглөөний цайны цэрний үнэ: 472.2 т.төл

МЭДЭЭЛЛИЙН САМБАР

АЛСЫН ХАРАА

ЭРХЭМ ЗОРИЛГО

ЭРХЭМЛЭХ ЗҮЙЛС



БНСУ-ын КОЙКА хамтын ажиллагааны байгууллагад танилцуулах төсөл хөтөлбөр боловсруулан ажиллалаа.



БНСУ-ын КОЙКА хамтын ажиллагааны байгууллагад танилцуулахаар “Монгол Улсын галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийг бэхжүүлэх галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, хяналтын системийг байгуулах” төслийг боловсруулан. “ГТХЗНТ-ийн ТЭЗҮ, барилгын ажлын зураг боловсруулах болон зөвлөх үйлчилгээ авах” төслийн материалыг боловсруулан ажиллаж байна.



ГТХЗНТ-ийн нөөц удирдлагын төв, орон сууцны барилгыг барих ажлын хүрээнд:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 250 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдсан “Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд яамны болон зарим харьяа байгууллагын албан хаагчдын орон сууцны нөхцөлийг судалж, сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн хурал ЗТХЯ-нд хуралдаж, хурлын шийдвэрийн дагуу ажилласан байна.

“Нөөц удирдлагын төв”-ийн барилга барих газрыг олгоход ЗТХЯ-аас дэмжлэг үзүүлж, шийдвэрийн дагуу ажиллалаа. ЗТХ-ийн дэд сайдаас СХД-ийн Засаг дарга болон дүүргийн газрын албанд холбогдох албан бичиг хүргүүлсэн.

Санал, хүсэлт



ЗТХЯ-ны харьяа газруудтай хамтран ажиллах талаар хүсэлт хүргүүлсэн.

Түдгэлзсэн

2019.02.13-ны 32 тоот албан бичиг. Төвийн болон яамны албан хаагчдын орон сууцны барилга барих төсөлд хамтран ажиллах хүсэлт





Барилгын зураг төсөл боловсруулах компаниудаас зураг төслийн үнийн санал ирүүлсэн.




2019 оны 2 дугаар сард өссөн дүнгээр зорчигч тээвэрлэлт 380.0 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9.8%-аар буурсан, ачаа тээвэрлэлт нь 4353.5 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 6.1%-аар өссөн үзүүлэлттэй байна.



ИНФОГРАФИК




Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт




Зорчигч тээвэрлэлт 2019 оны хоёрдугаар сард 172.8 мян.зорчигч тээвэрлэсэн, ачаа тээвэрлэлт нь энэ сарын байдлаар 2025.1 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.

Ачилт- ачааны төрлөөр /2019 оны 2 дугаар сард/




Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/




Дамжин өнгөрсөн ачаа 2019 оны хоёрдугаар сард 251.4 мян.тн ачсан байна.

Ачилтаар 2019 оны хоёрдугаар сард нүүрс, төмрийн хүдэр, зэс, молибдений баяжмал, нефтийн бүтээгдэхүүн, барилгын материал өссөн үзүүлэлттэй байна. Нийт 1586.3 мян.тн ачсан байна.





 8-р давхар, Хан-Уул цамхаг,
Б.Шаравын гудамж 6,
3-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17042, Монгол Улс

